



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гаалийн Ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/223-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: Д.Чулуунцэцэг

Утас: 70363036 Цахим хаяг: [chuluuntsetseg.d@audit.local](mailto:chuluuntsetseg.d@audit.local)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3.Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	15
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Албан шаардлага, Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
НА	Нотлох аудит
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОХУ	Оросын холбооны улс



Г СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ӨНӨБОЛД ТАНАА

## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.14 № СЭА-2022/ААБ-НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

СЭА-2022/223-НА-СТА-ТШЗ

018020035

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа бол <sup>3</sup> материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	127,275,678.67	190,774,850.86
33	АВЛАГА	1,769,095.26	29,464,305.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,597,095.26	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	29,452,305.00
33500	Бусад авлага	172,000.00	12,000.00
3351	Байгууллагаас авах авлага	172,000.00	12,000.00
34	УРЬДЧИЛГАА	9,864,000.00	39,727,000.00
34600	Урьдчилж төлсөн зардал	9,864,000.00	0.00
34710	Урьдчилгаа тооцоо	0.00	39,727,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0.00	39,727,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	115,642,583.41	121,583,545.86
35100	Түүхий эд материал	1,486,527.46	1,839,727.46
35110	Тусгай зориулалттай материал	1,364,527.46	1,364,527.46
35130	Эм, боох материал	122,000.00	475,200.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7,080,232.75	1,961,695.00
35400	Хангамжийн материал	107,075,823.20	117,782,123.40
35410	Бичиг хэргийн материал	1,385,000.00	2,306,800.00
35420	Аж ахуйн материал	9,504,600.00	24,501,809.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,400,000.00	3,305,500.00
35440	Түлш, шатах тослох материал	30,387,100.00	24,035,950.00
35470	Бусад хангамжийн материал	62,399,123.20	63,632,064.40
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,142,403,288.91	8,341,412,682.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,142,403,288.91	8,341,412,682.96
39200	Биет хөрөнгө	8,078,226,474.91	7,261,409,371.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,657,390,119.98	6,610,270,948.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,126,561,065.73	1,372,108,981.99
39203	Авто-тээврийн хэрэгсэл	523,602,170.00	452,602,170.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	286,057,725.52	258,641,058.80
39205	Машин, тоног төхөөрөмж (компьютер)	11,559,718,296.27	11,669,400,957.57
39206	Хуримтлагдсан элэгдэл	9,269,430,198.93	10,264,668,851.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	88,471,543.50	88,971,543.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	75,292,578.04	79,030,531.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	87,942,799.91	497,409,650.91
39215	Хуримтлагдсан элэгдэл	83,371,524.25	84,611,113.17
39217	Ном	1,814,637.72	1,814,637.72
39300	Биет бус хөрөнгө	1,064,176,814.00	1,080,003,311.50
39301	Програм хангамж	2,899,025.37	4,879,025.37
39302	Хуримтлагдсан элэгдэл	2,672,150.37	2,754,650.37
39303	Бусад биет бус хөрөнгө	1,142,507,389.12	1,156,436,386.62
39304	Хуримтлагдсан элэгдэл	78,557,450.12	78,557,450.12
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,269,678,967.58	8,532,187,533.82
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,466,935.00	29,452,305.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,466,935.00	29,452,305.00
41300	Өглөг	4,466,935.00	29,452,305.00
41360	Бусад өглөг	4,466,935.00	29,452,305.00
41361	Байгууллагад өгөх өглөг	4,306,935.00	29,452,305.00
41362	Хувь хүмүүст өгөх өглөг	160,000.00	0.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН	9,265,212,032.58	8,502,735,228.82
51	Засгийн газрын хувь оролцоо	8,630,915,603.22	8,630,915,603.22
51101	Засгийн газрын оруулсан капитал	8,630,915,603.22	8,630,915,603.22
51200	Хуримтлагдсан үр дүн	-524,324,859.05	-1,286,801,662.81
51210	Өмнөх үеийн үр дүн	-524,324,859.05	-524,324,859.05
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-762,476,803.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,158,621,288.41	1,158,621,288.41
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГ	9,269,678,967.58	8,532,187,533.82

**2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

№	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,313,338,177.96	4,180,143,745.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	796,517,277.96	93,636,053.00
120	Нийтлэг татварын бус орлого	796,517,277.96	93,636,053.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	757,350,390.80	63,869,655.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,455,625.00	3,436,055.00
1200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	753,894,765.80	60,433,600.00
120005	Түрээсийн орлого	38,198,887.16	26,395,098.00
120009	Бусад орлого	968,000.00	3,371,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,516,820,900.00	4,086,507,692.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,516,820,900.00	3,496,961,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,516,820,900.00	3,496,961,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	589,546,092.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	589,546,092.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,830,427,444.63	4,942,584,083.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,632,516,236.87	2,523,812,392.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,382,485,759.66	4,520,730,410.15
21	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	2,632,516,236.87	2,523,812,392.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	2,338,088,077.85	2,225,516,105.53
210101	Үндсэн цалин	1,353,206,287.59	1,207,416,776.42
210102	Нэмэгдэл	639,356,163.26	706,034,829.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,526,000.00	107,064,500.00
210104	Урамшуулал	287,999,627.00	205,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	294,428,159.02	298,296,286.84
210201	Тэтгэврийн даатгал	201,991,730.74	209,023,871.89
210202	Тэтгэмжийн даатгал	23,949,027.37	22,704,536.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,590,393.66	17,807,468.25
210204	Ажилгүйдлийн даатгал	4,536,091.82	4,327,382.96
210205	Эрүүл мэндийн даатгал	45,360,915.43	44,433,027.65
2103	<и>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	209,010,149.59	119,023,973.78
210301	Гэрэл, цахилгаан	115,650,780.31	45,823,535.78
210302	Түлш, халаалт	82,845,609.28	63,918,358.00
210303	Цэвэр, бохир ус	10,513,760.00	9,282,080.00
2104	<и>Хангамж, бараа материалын зардал	87,721,887.61	98,465,176.20
210401	Бичиг хэрэг	13,427,200.00	15,115,800.00
210402	Тээвэр, шатахуун	16,491,500.00	20,960,300.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,211,511.50	2,678,633.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,092,920.00	2,603,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	39,782,805.00	26,721,900.00
210408	Бараа материал акталсны зардал	12,715,951.11	30,385,543.20
2106	<и>Эд хогшил, урсгал засварын зардал	110,831,590.00	299,112,266.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,516,600.00	4,100,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	16,137,790.00	160,012,166.00
210604	Урсгал засвар	91,177,200.00	135,000,000.00
2107	<и>Томилолт, зочны зардал	934,800.00	0.00
210702	Дотоод албан томилолт	934,800.00	0.00
2108	<и>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,639,789.25	114,197,894.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,090,690.00	65,075,685.50
210803	Даатгалын үйлчилгээ	2,271,100.00	2,271,090.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	426,225.00	605,938.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,085,750.00	31,147,956.10
210807	Газрын төлбөр	54,032.00	63,752.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,513,992.25	14,846,472.75
2109	<и>Бараа үйлчилгээний бусад зардал	1,254,831,306.34	1,366,118,707.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	469,000.00	546,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,254,362,306.34	1,365,572,307.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	447,941,684.97	421,853,673.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,800,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	52,800,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	395,141,684.97	421,853,673.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	395,141,684.97	421,853,673.61
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-517,089,266.67	-762,440,338.76
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	36,465.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	36,465.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-517,089,266.67	-762,476,803.76

143998  
65 9055436

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,592,698,405.16	4,139,948,845.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	75,877,505.16	53,441,153.26
120	Нийтлэг татварын бус орлого	75,877,505.16	53,441,153.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,216,098.16	53,441,153.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,216,098.16	53,441,153.26
120009	Бусад орлого	10,661,407.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,516,820,900.00	4,086,507,692.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,516,820,900.00	3,496,961,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,516,820,900.00	3,496,961,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	589,546,092.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	589,546,092.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,592,698,405.16	4,139,948,845.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,631,706,833.10	2,523,812,392.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,121,800,906.19	3,662,323,026.65
21	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	2,631,706,833.10	2,523,812,392.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	2,337,671,766.58	2,225,516,105.53
210101	Үндсэн цалин	1,304,290,236.65	1,207,431,406.42
210102	Нэмэгдэл	687,855,902.93	706,020,199.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,526,000.00	107,064,500.00
210104	Урамшуулал	287,999,627.00	205,000,000.00
2102	<u>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	294,035,066.52	298,296,286.84
210201	Тэтгэврийн даатгал	201,598,638.24	209,023,871.89
210202	Тэтгэмжийн даатгал	23,949,027.37	22,704,536.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,590,393.66	17,807,468.25
210204	Ажилгүйдлийн даатгал	4,536,091.82	4,327,382.96
210205	Эрүүл мэндийн даатгал	45,360,915.43	44,433,027.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,449,849.59	114,720,823.78
210301	Гэрэл, цахилгаан	115,650,780.31	45,823,535.78
210302	Түлш, халаалт	74,910,309.28	59,149,208.00
210303	Цэвэр, бохир ус	9,888,760.00	9,748,080.00
2104	<u>Хангамж, бараа материалын зардал	84,360,536.50	75,227,733.00
210401	Бичиг хэрэг	14,071,200.00	16,073,600.00
210402	Тээвэр, шатахуун	18,213,500.00	18,211,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,211,511.50	2,678,633.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,602,920.00	2,603,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,261,405.00	35,661,500.00
2106	<u>Эд хогшил, урсгал засварын зардал	112,327,490.00	263,857,675.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,892,500.00	6,500,000.00
210602	Тавилга	0.00	500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	23,257,790.00	121,857,675.00
210604	Урсгал засвар	63,177,200.00	135,000,000.00
2107	Томиллолт, зочны зардал	934,800.00	0.00
210702	Дотоод албан томилолт	934,800.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	91,552,397.00	298,032,771.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74,954,690.00	94,938,685.50
210803	Даатгалын үйлчилгээ	2,271,100.00	2,271,090.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	426,225.00	605,938.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,395,750.00	198,025,506.00
210807	Газрын төлбөр	54,032.00	63,752.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,252,600.00	1,940,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	469,000.00	386,671,631.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	386,125,231.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	469,000.00	546,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	470,897,498.97	477,625,818.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,800,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	52,800,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	418,097,498.97	448,173,513.61
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	395,141,684.97	421,853,673.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,955,814.00	26,319,840.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	29,452,305.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	29,452,305.00

43998  
9055436

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	8,630,915,603.22	1,158,621,288.41	-8,264,857.15	9,781,272,034.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	393,092.77	393,092.77
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	-517,089,266.67	-517,089,266.67
2020 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	8,630,915,603.22	1,158,621,288.41	-524,324,859.05	9,265,212,032.58
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	-762,476,803.76	-762,476,803.76
2021 оын 12 сарын 31-р үлдэгдэл	8,630,915,603.22	1,158,621,288.41	-1,286,801,662.81	8,502,735,228.82

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,516,961,600.00	3,550,402,753.26	-33,441,153.26	100.95
II	НИИТ ЗАРЛАГЫН ДҮН	3,516,961,600.00	3,550,402,753.26	-33,441,153.26	100.95
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,516,961,600.00	3,102,229,239.65	414,732,360.35	88.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	715,294,500.00	578,416,847.28	136,877,652.72	80.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	2,442,466,600.00	2,225,516,105.53	216,950,494.47	91.12
210101	Үндсэн цалин	1,281,631,500.00	1,207,431,406.42	74,200,093.58	94.21
210102	Нэмэгдэл цалин	820,425,100.00	706,020,199.11	114,404,900.89	86.06
210103	Унаа хоолны нэмэгдэл	135,410,000.00	107,064,500.00	28,345,500.00	79.07
210104	Урамшуулал	205,000,000.00	205,000,000.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	359,200,500.00	298,296,286.84	60,904,213.16	83.04
210201	Тэтгэврийн даатгал	250,977,300.00	209,023,871.89	41,953,428.11	83.28
210202	Тэтгэмжийн даатгал	17,315,700.00	22,704,536.09	-5,388,836.09	131.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	43,289,300.00	17,807,468.25	25,481,831.75	41.14
210204	Ажилгүйдлийн даатгал	4,328,900.00	4,327,382.96	1,517.04	99.96
210205	Эрүүл мэндийн даатгал	43,289,300.00	44,433,027.65	-1,143,727.65	102.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	237,381,500.00	114,720,823.78	122,660,676.22	48.33
210301	Гэрэл, цахилгаан	140,246,300.00	45,823,535.78	94,422,764.22	32.67
210302	Түлш, халаалт	87,246,100.00	59,149,208.00	28,096,892.00	67.80
210303	Цэвэр, бохир ус	9,889,100.00	9,748,080.00	141,020.00	98.57
2104	Хангамж, бараа материалын зардал	76,509,700.00	75,227,733.00	1,281,967.00	98.32
210401	Бичиг хэрэг	16,073,600.00	16,073,600.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	18,214,300.00	18,211,000.00	3,300.00	99.98
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,956,900.00	2,678,633.00	1,278,267.00	67.70
210405	Хог, хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,603,400.00	2,603,000.00	400.00	99.98
210406	БҮТЭЭ үйлс	35,661,500.00	35,661,500.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	263,357,800.00	263,357,675.00	125.00	100.00
210601	Багаж, техник хэрэгсэл	6,500,000.00	6,500,000.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	121,857,800.00	121,857,675.00	125.00	100.00
210604	Урсгал засвар	135,000,000.00	135,000,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	0.00	1,500,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	0.00	1,500,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	133,999,100.00	122,584,215.50	11,414,884.50	91.48
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	102,320,000.00	94,938,685.50	7,381,314.50	92.79
210803	Даатгалын үйлчилгээ	2,271,100.00	2,271,090.00	10.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	608,000.00	605,938.00	2,062.00	99.66
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	207,000.00	187,000.00	20,000.00	90.34
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,192,000.00	22,576,950.00	2,615,050.00	89.62
210807	Газрын төлбөр	101,000.00	63,752.00	37,248.00	63.12
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,300,000.00	1,940,800.00	1,359,200.00	58.81
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,546,400.00	2,526,400.00	20,000.00	99.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,980,000.00	20,000.00	99.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	546,400.00	546,400.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	448,173,513.61	-448,173,513.61	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	448,173,513.61	-448,173,513.61	0.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	421,853,673.61	-421,853,673.61	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	26,319,840.00	-26,319,840.00	0.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,516,961,600.00	3,550,402,753.26	-33,441,153.26	100.95
1200042	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	20,000,000.00	53,441,153.26	-33,441,153.26	267.21
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,496,961,600.00	3,496,961,600.00	0.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,496,961,600.00	3,496,961,600.00	0.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	589,546,092.00	560,093,787.00	29,452,305.00	95.00
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	589,546,092.00	560,093,787.00	29,452,305.00	95.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	589,546,092.00	560,093,787.00	29,452,305.00	95.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	589,546,092.00	560,093,787.00	29,452,305.00	95.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	0.00	100.00
210602	Тавилга	500,000.00	500,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	184,682,691.00	175,448,556.00	9,234,135.00	95.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	184,682,691.00	175,448,556.00	9,234,135.00	95.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	404,363,401.00	384,145,231.00	20,218,170.00	95.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	404,363,401.00	384,145,231.00	20,218,170.00	95.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	589,546,092.00	560,093,787.00	29,452,305.00	95.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	589,546,092.00	560,093,787.00	29,452,305.00	95.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	-29,452,305.00	29,452,305.00	0.00
131104	Нэмэлт санхүүжилтийн орлого	589,546,092.00	589,546,092.00	0.00	100.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар нь “ Мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэхжүүлэх замаар үндэсний аюулгүй байдлыг хангаж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжинэ ” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих,
- Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих,
- Гаалийн бүрдүүлэлт хийж гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих,
- Гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах,
- Гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл гаргах,
- Гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах,
- Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх,
- Гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх,
- Гаалийн тухай хуульд заасны дагуу оюуны өмчийн эрхийг хамгаалах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Гаалийн ерөнхий газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас болон шууд захирагчийн дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ


Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,830,427.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 72,456.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 50,719.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 735,593.0 мянган төгрөгөөр буюу 8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.



Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Хувь хүнээс авах авлага	1,597.1	-	-1,597.1
Татаас санхүүжилтийн авлага	-	29,452.3	29,452.3
Байгууллагаас авах авлага	172.0	12.0	-160.0
Урьдчилж төлсөн зардал	9,864.0	39,727.0	29,863.0
Бараа материал	115,642.5	121,583.5	5,941.0
Үндсэн хөрөнгө	9,142,403.3	8,343,311.1	-799,092.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>9,269,678.9</b>	<b>8,534,085.9</b>	<b>-735,593.0</b>
Өр төлбөр	4,466.9	29,452.3	24,985.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,265,212.0	8,504,633.6	-760,578.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>9,269,678.9</b>	<b>8,534,085.9</b>	<b>-735,593.0</b>

Тайлант онд хувь хүнээс авах авлага дансны эхний үлдэгдэл 1,597.6 мянган төгрөгийг барагдуулж, үлдэгдэлгүй тайлагнагдсан бөгөөд байгууллагаас авах авлага дансны үлдэгдэл 160.0 мянган төгрөгөөр буурч, ХХОАТ-ын хөнгөлөлтийн зөрүүгээс үүссэн 12.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Татаас санхүүжилтийн авлага данс нь 29,452.3 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлсэн, урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 39,727.0 мянган төгрөг болж 29,863.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Гаалийн ерөнхий газраас нэг цэгийн үйлчилгээнд тавилга хийлгэхээр бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 40,000.0 мянган төгрөг хуваарилж олгосныг Таван хан уул ХХК, Экструд хаус ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж 39,727.0 мянган төгрөгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 121,583.5 мянган төгрөг болж 5,941.0 мянган төгрөгөөр өссөн нь Гаалийн ерөнхий газраас 7,937.6 мянган төгрөгийн тооцоот хуудас, улаан ломбо, хяналтын тэмдэг, 42,270.0 мянган төгрөгийн 1 удаагийн хамгаалах хэрэгсэл, аймгийн Онцгой комиссоос 10,226.0 мянган төгрөгийн 1 удаагийн хамгаалах хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авч, зарцуулсан бөгөөд үлдэгдлийг аж ахуйн материал дансанд тайлагнаснаас голлон шалтгаалсан байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 358,267.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, систем хоорондын шилжүүлгээр 50,207.6 мянган төгрөгийн, аймгийн Онцгой комиссоос 10,226.0 мянган төгрөгийн, Мосгор транс

ХХК-аас хандиваар 2,670.0 мянган төгрөгийн бараа материал, шатахууны урамшууллаар 701.0 мянган төгрөгийн шатахууныг тус тус үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, 385,746.0 мянган төгрөгийн материалыг зарцуулан, 30,230.5 мянган төгрөгийн материалыг байгууллагын даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/22 дугаар тушаалыг үндэслэн акталж, 36.5 мянган төгрөгийн хүчингүй үнэт цаасны үлдэгдлийг шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр/* 20,481,785.3 мянган төгрөг болж өмнөх оноос 417,439.4 мянган төгрөгөөр өссөн нь Алтанбулаг боомтын улаан бүсэд баригдсан 2 түр байр, цэвэр бохир усны шугам, 138,705.8 мянган төгрөгийн теле хяналтын систем, 13,929.0 мянган төгрөгийн хөрөнгийн бусад биет хөрөнгө, аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжсэн 500.0 мянган төгрөгийн хөлдөөгч, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,980.0 мянган төгрөгийн санхүүгийн программ зэргийг тус тус орлогоор бүртгэж, 71,000.0 мянган төгрөгийн Ниссан маркийн авто машиныг Дорнод аймгийн Гаалийн газарт */ГЕГ-ын даргын 2021 оны А/141 дугаар тушаалаар/* шилжүүлж, 76,142.3 мянган төгрөгийн авто пүү, дэлгэц процессор, гар станц зэрэг хөрөнгийг */ГЕГ-ын даргын 2021 оны А/257, А/265 дугаар тушаалаар/* акталж, данснаас хассантай холбоотой байна.

Алтанбулаг боомтын 12 түр байр болон теле хяналтын системийн 589,046.1 мянган төгрөгийн барьцаа төлбөр болох 29,452.3 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас Сангийн яаманд татан төвлөрүүлсэн тул гүйцэтгэгч байгууллагад төлөх өглөгөөр бүртгэсэн байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 4,180,143.7 мянган төгрөг болж өмнөх оноос 133,194.5 мянган төгрөгөөр буюу 3 хувиар буурсан байна. Энэ нь Ковид-19 цар тахлын улмаас Алтанбулаг боомтын зорчих хэсэг хаагдсанаас ХААН банк, татваргүй барааны дэлгүүрүүд, гаалийн бүрдүүлэлтийн байгууллагуудын түрээсийн төлбөр буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,942,584.1 мянган төгрөг болж өмнөх оноос 112,157.0 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн нь албан хаагчдад олгосон хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийн зардал 143,874.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 4,078,750.0 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 561,788.4 мянган төгрөгөөр бууруулж, 3,516,961.6 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,516,961.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 3,496,961.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 20,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,496,961.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 53,441.1 мянган төгрөг, нийт 3,550,402.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,102,229.3 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 448,173.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,102,229.3 мянган төгрөг буюу 88.2 хувьтай тайлагнагдсан байна.

Алтанбулаг боомтын бүтээн байгуулалттай холбоотойгоор зарим барилга байгууламж цахилгаан эрчим хүчээр хангагдаагүйгээс тогтмол зардал 122,660.7 мянган төгрөгөөр, 30 орон тоо дутуу ажилласнаас цалин, НДШ-ийн зардал 277,854.7 мянган төгрөгөөр, харуул хамгаалалтын Шүрэн үндэс ХХК-тай байгуулсан гэрээг цуцалж, сахиул манаач томилон ажиллуулснаар бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 11,435.0 мянган төгрөгөөр, томилолтын зардал 1,500.0 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардал 1,281.9 мянган төгрөгөөр зэрэг нийт 414,732.3 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд Сангийн яамнаас Алтанбулаг боомтын 12 түр байрны санхүүжилтэд 589,046.1 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлж 500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож, нийт 589,546.1 мянган төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

**3.7.1** Алтанбулаг боомтын шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй засварын ажлын хүрээнд 2021 оны 10 дугаар сард тус боомт дахь уурын зуухыг шинэчилснээр хоногт хэрэглэх нүүрсний хэрэглээ 3 дахин өссөн байна. Цаашид бодит хэрэглээнд үндэслэн түлшний зардлыг төлөвлөж, санхүүжүүлэх нь зүйтэй юм.

**3.7.2** Гаалийн ерөнхий газар, харьяа газар, хэлтэс, хороодод мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу бусад биет бус хөрөнгөнд бүртгэлтэй тодорхой ашиглалтын хугацаагүй 46,884.3 мянган төгрөгийн өртөгтэй дугаар таних лиценз, системийн камерийн холболтын лиценз, теле хяналтын нэгдсэн удирдлагын лиценз зэрэг хөрөнгүүдийг хорогдуулж тооцоогүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 119 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 16,114.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан Алтанбулаг боомтод шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 42,756.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,898.3 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 39,727.0 мянган төгрөгийн

алдаа, зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,131.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

#### 4.1 Залруулсан алдаа

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 8,143.0 мянган төгрөгийн 20 ширхэг хөрөнгөд 1,898.3 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг байгуулалгүйгээр санхүүгийн тайланд тусгасныг залруулав.

#### 4.2 Албан шаардлага

1. Шууд гэрээ байгуулах босго үнээс давсан Алтанбулаг хилийн боомтод тавилга хийлгүүлэх 39,727.0 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар бус төсөвт өртгийг хуваан Таванхан уул болон Экструд хаус ХХК-иудаар гүйцэтгүүлэхээр шууд гэрээ байгуулж, төлбөрийг урьдчилан шилжүүлж, авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 8.5 дахь “Энэ хуулийн 8.1 дэх заасан босго үнэнд багтаах...зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санахүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, төсвийг зохистой удирдах замаар авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

#### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

### 1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

#### 1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 1,131.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор

баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар	3	42,756.7	1	1,898.3	-	-	1	39,727.0	1	1,131.4